

“УЛААНСАН” ХК

2024 оны 09 сарын 27-ны өдөр

№ 24/02

Улаанбаатар хот

“УЛААНСАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

КОМПАНИЙН БҮРТГЭЛТЭЙ ХАЯГИЙГ ӨӨРЧЛӨХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, “Улаансан” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх хэсэг болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн бүртгэлтэй хаягийг “Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 17 давхар” болгон өөрчилсүгэй.
2. Компанийн дүрэмд холбогдох өөрчлөлтийг тусган дүрмийн шинэчилсэн найруулгыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолоор баталсугай.
3. Компанийн бүртгэлтэй хаягийг орон нутгаас Улаанбаатар хот дахь хаягт шилжүүлэн бүртгүүлэхтэй холбоотойгоор Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА _____ Ө. АШХҮҮ



“УЛААНСАН” ХК

2024 оны 09 сарын 27-ны өдөр

№24/03

Улаанбаатар хот

“УЛААНСАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, “Улаансан” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх хэсэг болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг Хавсралтаар баталсугай.
- Компанийн дүрмийг хуульд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад бүртгүүлэх ажилд хяналт тавьж, холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.АШХҮҮ

“УЛААНСАН” ХК

2024 оны 09 сарын 27-ны өдөр

№24/04

Улаанбаатар хот

“УЛААНСАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

КОМПАНИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ШИНЭЭР АВАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, “Улаансан” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх хэсэг болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Компанийн бүртгэлтэй хаягийг орон нутгаас Улаанбаатар хот дахь хаягт шилжүүлэн бүртгүүлэхтэй холбоотойгоор Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авсугай.
- Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.АШХҮҮ

“УЛААНСАН” ХК

2024 оны 09 сарын 27-ны өдөр

№24/05

Улаанбаатар хот

“УЛААНСАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, “Улаансан” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь хэсэг болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгож чөлөөлсүгэй. Үүнд:

Ердийн гишүүд:

- Ц.Энхцаг
- Г.Лхагвасүрэн
- Г.Буянтогтох
- Г.Ундрам
- Г.Баасансүрэн
- Б.Сувдаа

Хараат бус гишүүд:

- М.Эрдэнэ-Очир
- С.Алтангэрэл
- Л.Балдорж

- Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.АШХҮҮ

“УЛААНСАН” ХК

2024 оны 08 сарын 27-ны өдөр

№24/06

Улаанбаатар хот

“УЛААНСАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, “Улаансан” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн дугаар зүйлийн 8.4.8 дэх хэсэг болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд доор дурдсан нэр бүхий гишүүдийг сонгон, томилсугай: Үүнд:

Ердийн гишүүд:

- Галнямын Уянга
- Чулууны Ганхуяг
- Хүрэлбаатарын Билгүүн
- Сүхчулууны Нямгэрэл
- Батбилэгийн Золбоо
- Чадраабалын Даваасамбуу

Хараат бус гишүүд:

- Гандоржийн Зол-Эрдэнэ
- Цогбадрахын Батбаяр
- Алтангэрэлийн Азбаяр

- Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.АШХҮҮ